



**ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

「Сагсан бөмбөгийн шилжин явах цомын төлөөх
тэмцээнд оролцох зардал гаргах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 10 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 8.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Спортын шигшээ баг тамирчдын Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зохион байгуулж буй “BUSINESS LEAGUE-2019” Сагсан бөмбөгийн шилжин явах цомын төлөөх тэмцээнд оролцох зардлыг хавсралтаар баталсугай.

2. Тэмцээний зардалд 1 514 000 /нэг сая таван зуун арван дөрвөн мянган/ төгрөгийг зарцуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /И.Урантогос/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.БАТСАЙХАН

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын
даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны
өдрийн 4/34..... дүгээр тушаалын хавсралт

"BUSINESS LEAGUE-2019" САГСАН БӨМБӨГИЙН
ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫН ТӨЛӨӨХ
ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ЗАРДАЛ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
1	Тэмцээний хураамж	Баг	1	800 000	800 000
2	Хоол	Өдөр/төг	12	7 000	504 000
3	Ус	ширхэг	300	700	210 000
НИЙТ					1 514 000